

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/56/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

“Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых

Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт.....	19
Байхгүй	19
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**БУЯНТ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ С.ЛХАМЖАВ ТАНАА**

᠒᠐᠒1.᠐᠒.21 № ᠑4
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Buyant+tsetserleg-dugneIt

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Buyant+tsetserleg-dugneit

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгрөгөөр Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,837,566.00	8,438,567.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	22,410.00	189,971.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	20,000.00	-
335	Бусад авлага	2,410.00	189,971.00
3351	Байгууллагаас авах авлага	2,410.00	189,971.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,815,156.00	8,248,596.00
354	Хангамжийн материал	3,815,156.00	8,248,596.00
35420	Аж ахуйн материал	2,562,053.00	2,838,953.00
35460	Хүнсний материал	1,253,103.00	5,409,643.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	279,085,702.27	287,931,214.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	279,085,702.27	287,931,214.38
392	Биет хөрөнгө	274,629,702.27	283,475,214.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	248,273,820.00	248,273,820.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,819,604.56)	(20,578,161.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,180,936.00	21,438,991.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,529,083.50)	(12,224,058.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,144,648.20	51,592,383.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(47,492,693.59)	(45,065,621.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,854,290.00	44,854,290.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,397,303.28)	(7,231,121.44)
39217	Ном	2,414,693.00	2,414,693.00
393	Биет бус хөрөнгө	4,456,000.00	4,456,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(300,000.00)

39303	Бусад биет бус хөрөнгө	4,456,000.00	4,456,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>282,923,268.27</u>	<u>296,369,781.38</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>-</u>	<u>-</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>282,923,268.27</u>	<u>296,369,781.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	282,923,268.27	296,369,781.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	98,647,780.00	98,647,780.00
51101	Өмч: - төрийн	98,647,780.00	98,647,780.00
512	Хуримтлагдсан үр дүн	(114,795,630.73)	(101,349,117.62)
51210	Өмнөх үеийн үр дүн	(124,501,469.97)	(114,795,630.73)
51220	Тайлант үеийн үр дүн	9,705,839.24	13,446,513.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	299,071,119.00	299,071,119.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>282,923,268.27</u>	<u>296,369,781.38</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	344,448,340.00	337,115,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	344,448,340.00	337,115,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	330,084,840.00	323,384,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	25,062,340.00	21,300,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	305,022,500.00	302,084,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,363,500.00	13,526,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,363,500.00	13,526,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	334,742,500.76	323,669,186.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334,742,500.76	323,669,186.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	328,865,250.76	323,669,186.89

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247,305,297.00	246,515,405.00
210101	Үндсэн цалин	230,858,294.00	215,987,505.00
210104	Урамшуулал	9,255,503.00	18,234,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,191,500.00	12,293,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,899,993.00	33,383,310.00
210201	Тэтгэврийн даатгал	28,899,993.00	23,492,710.00
210202	Тэтгэмжийн даатгал		2,472,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,978,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал		494,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал		4,945,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,353,830.00	13,065,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,277,330.00	1,168,000.00
210302	Түлш, халаалт	13,076,500.00	11,897,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,960,590.00	3,075,200.00
210401	Бичиг хэрэг	462,300.00	742,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,424,200.00	444,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	452,000.00
210404	Ном, хэвлэл	47,900.00	62,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	651,190.00	1,373,900.00
2105	Нормативт зардал	17,955,805.00	11,231,684.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	157,750.00	155,800.00
210502	Хоол, хүнс	17,526,155.00	10,206,810.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	271,900.00	869,074.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	210,000.00
210604	Урсгал засвар		210,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	172,000.00
210702	Дотоод албан томилолт		172,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	418,670.00	354,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	119,370.00	104,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	299,300.00	250,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,971,065.76	15,661,787.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	517,000.00	585300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,454,065.76	15,076,487.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,877,250.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,877,250.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,877,250.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	9,705,839.24	13,446,513.11
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9,705,839.24	13,446,513.11

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	94,191,780.00	299,071,119.00	-33,047,797.20	360,215,101.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,191,780.00	299,071,119.00	-33,047,797.20	360,215,101.80
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн			-19,709,382.17	-19,709,382.17
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,647,780.00	299,071,119.00	(114,795,630.73)	282,923,268.27
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	98,647,780.00	299,071,119.00	(114,795,630.73)	282,923,268.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	98,647,780.00	299,071,119.00	-114,795,630.73	282,923,268.27
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			13,446,513.11	13,446,513.11

2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,647,780.00	299,071,119.00	-101,349,117.62	296,369,781.38
---------------------------------------	---------------	----------------	-----------------	----------------

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	319386000.00	315815700.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	319386000.00	315815700.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	305022500.00	302084200.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	305,022,500.00	302,084,200.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	205000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14363500.00	13526500.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,363,500.00	13,526,500.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	314491000.00	313193700.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	314491000.00	313193700.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	308613750.00	313193700.00	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,926,500.00	246,685,376.00	
210101	Үндсэн цалин	211,279,800.00	216,157,476.00	
210104	Урамшуулал	19,353,600.00	18,234,800.00	
210105	Гэрээт ажлын хөлс	12,293,100.00	12,293,100.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33288700.00	33380900.00	
210201	Тэтгэврийн даатгал	23,425,400.00	23,490,300.00	
210202	Тэтгэмжийн даатгал	2,454,300.00	2,472,700.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,984,100.00	1,978,100.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	529,000.00	494,500.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	4,895,900.00	4,945,300.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,346,330.00	13,139,500.00	
210301	Гэрэл, цахилгаан	1,277,330.00	1,203,500.00	
210302	Түлш, халаалт	13,069,000.00	11,936,000.00	

2104	Хангамж, бараа материалын зардал	5,284,600.00	3,113,700.00
210401	Бичиг хэрэг	523,100.00	576,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,424,200.00	444,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	452,000.00
210404	Ном, хэвлэл	47,900.00	62,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	914,400.00	1,578,900.00
2105	Нормативт зардал	11872750.00	15541624.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	157,750.00	155,800.00
210502	Хоол, хүнс	11,225,100.00	14,363,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	489,900.00	1,022,474.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	210000.00
210604	Урсгал засвар		210000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	172000.00
210702	Дотоод албан томилолт		172000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	418670.00	354300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	119,370.00	104,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	299,300.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	476200.00	596300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	476200.00	596300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5877250.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17170.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17170.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5860080.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5860080.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4895000.00</u>	<u>2622000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4895000.00	2622000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4895000.00	2622000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4895000.00	2622000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,895,000.00	2,622,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-4895000.00</u>	<u>-2622000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	329,639,300.00	315,610,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	329,639,300.00	315,610,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	329,639,300.00	315,610,700.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247,266,100.00	246,685,376.00
210101	Үндсэн цалин	216,738,200.00	216,157,476.00
210104	Урамшуулал	18,234,800.00	18,234,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,293,100.00	12,293,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,380,900.00	33,380,900.00
210201	Тэтгэврийн даатгал	23,490,300.00	23,490,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,472,700.00	2,472,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,978,100.00	1,978,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	494,500.00	494,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,945,300.00	4,945,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,316,500.00	13,316,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,268,500.00	1,268,500.00
210302	Түлш, халаалт	12,048,000.00	12,048,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,231,700.00	2,908,700.00
210401	Бичиг хэрэг	279,000.00	576,000.00
210402	Тээвэр, шатахуун	444,000.00	444,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	452,000.00	452,000.00
210404	Ном, хэвлэл	62,800.00	62,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	993,900.00	1,373,900.00
2105	Нормативт зардал	31,554,200.00	15,596,624.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,800.00	155,800.00
210502	Хоол, хүнс	31,045,000.00	14,363,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	453,400.00	1,077,474.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,000.00	210,000.00
210604	Урсгал засвар	210,000.00	210,000.00
2107	Томилолт, зочны зардал	279,000.00	172,000.00
210702	Дотоод албан томилолт	279,000.00	172,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	354,600.00	354,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,600.00	104,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,046,300.00	2,986,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,046,300.00	2,986,300.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	329,639,300.00	315,610,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	316,112,800.00	302,084,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	316,112,800.00	302,084,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,526,500.00	13,526,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	13,526,500.00	13,526,500.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12
620003	Үйлчлэх ажилтан	10	10
620004	Гэрээт ажилтан	2	2
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	125	125
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	125	125
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	13	13
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	205000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	205000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	205000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	205000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	205000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	205000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	205000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	205000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор В.Хуандых гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага ба тайлант онд "Сургуулийн өмнөх боловсролыг хөгжүүлэх сургалтыг насанд хүрэгчид олон нийтийн дэмжлэгтэйгээр бие даасан байдлыг хангах боломжийг бүрдүүлэх" зорилгын хүрээнд дараах 5 дэд зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын чанарыг сайжруулна.
3. Хүүхэд бүрийн онцлогт тохируулж хөгжүүлэхэд эцэг эхчүүдтэй хамтарч ажиллана.
4. Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалж, аюулгүй хоол хүнсээр хангана.
5. Багш, ажилчдын үүрэг хариуцлага, мэдлэг боловсролыг дээшлүүлэн олон нийтийн төлөөлөлүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн харъяа төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийдэг.

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд 2021 онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба шалгалт хийгээгүй байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжтэй ба эрхлэгчийн тушаалаар баталсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна. Тус цэцэрлэгийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар аудитад туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 334.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13.5 сая төгрөгөөр буюу 4.7 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	22.4	189.9	167.5
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	3,815.1	8,248.6	4,433.5
Үндсэн хөрөнгө	279,085.7	287,931.2	8,845.5
Нийт хөрөнгө	282,923.3	296,369.8	13,446.5
Өр төлбөр	0.00	0.00	0.00

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	282,923.3	296,369.8	13,446.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>282,923.3</u>	<u>296,369.8</u>	<u>13,446.5</u>

Мөнгөн хөрөнгө, урьдчилгаа дансууд оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага данс оны эцэст 0.18 сая төгрөг болж 0.16 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Оны эхэнд ажилчдаас авах 0.02 сая төгрөгийн авлагатай байсныг барагдуулж, оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлд 0.2 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 8.2 сая төгрөг болж 4.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 30.3 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч үйл ажиллагаандаа 25.8 сая төгрөгийн бараа материал зарцуулж, бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн нь тайлант оны худалдан авалтаас зарцуулагдаагүй хүнсний материалын үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 287.9 сая төгрөг болж 8.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 2.6 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 21.0 сая, бусад эх үүсвэрээс авсан 0.3 сая буюу нийт 23.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 17.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд, хогшлыг акталж, үндсэн хөрөнгөнд 15.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

Өр төлбөр данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 296.4 сая төгрөг болж 13.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 13.4 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 337.1 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 7.3 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого, тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал санхүүжилт, хөрөнгийн санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 11.1 сая төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал болон урсгал шилжүүлэг байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны анх батлагдсан төсөв 339.9 сая төгрөг, тодотгосон төсөв 329.6 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 10.4 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Үүнд: Үндсэн үйл ажиллагааны зардлууд болох цалингийн зардлыг 2.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлийг 0.3 сая, хоол, хүнсний зардлыг 7.9 сая төгрөгөөр тус тус бууруулж тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 329.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 315.6 сая төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж судалж үзэхэд батлагдсан төлөвлөгөөнөөс 14.0 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна. Энэ нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг батлагдсанаас 14.0 сая төгрөгөөр дутуу авсантай холбоотой байна.

Хангамж, бараа материалын зардлыг 0.7 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 1.9 сая, нийт 2.6 сая төгрөгөөр хэтрүүлж хэмнэсэн зардлаас зарцуулсан байна. Цалингийн зардлыг 0.6 сая, нормативт зардлыг 16.0 сая, томилолт, зочны зардлыг 0.1 сая, нийт 16.7 сая төгрөгөөр хэмнэсэн үзүүлэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 0.2 сая төгрөгийн орлого хүлээн авч бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс худдалдан авах зардалд зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 онд шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 113 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй ба 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тус байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Тайлант оны 1 дүгээр улирлын төсвийн гүйцэтгэл болон таван сая төгрөгөөс дээш 102.2 сая төгрөгийн 4 орлогын гүйлгээ, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй, 0.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн тухай шийдвэрээ байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шилэн дансанд 6 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан зөрчилд зөвлөмж өгөгдсөн ба Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 06 дугаар сарын 14-ний өдрийн 19 дугаартай албан бичгээр зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр хийсэн ажлын тайланг шилэн дансанд байршуулаагүй, хэрэгжилтийг шалгаж үзэхэд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа тул зөрчил арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 140.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 105.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 34.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 105.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансанд 1 дүгээр улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, таван сая төгрөгөөс дээш 102.2 сая төгрөгийн 4 орлогын гүйлгээ, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй, 0.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн тухай шийдвэрээ байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 6.4.5, 6.4.8 дахь заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тайлант онд давтан гаргасан тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.

2. Буянт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд нийт 396.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 315.6 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Цэцэрлэгийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад тэвчиж болох урсгал зардлын төсөв 4.3 сая төгрөгийн 10 хувь 0.4 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, томилолтын зардлыг 0.1 сая төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлж, бусад урсгал зардлыг 3.2 сая төгрөгөөр хэтрүүлж тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалт болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тогтоолд заасны дагуу тэвчиж болох зардлаас хэмнэж зарцуулаагүй 3.2 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан зөрчилд албан шаардлага өгөв.

3. Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар хоолны зардлын төсвөөс 0.3 сая төгрөгийн тэтгэмж олгож төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.2 дахь гэсэн заалт болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Хоолны зардлын төсвийг зориулалт бус зарцуулсан зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалин, гэрэл цахилгаан, шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, хоол хүнс, албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх нийт 34.7 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, 0.1 сая төгрөгийн бараа материалыг орлогод авалгүй шууд зардлаар гаргасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 14.4, 14.4.5 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг орлого авч тооцоо хийх, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Буянт сумын Хүүхдийн цэцэрлэг	3	143.7					2	108.9	1	34.8

/сая төгрөгөөр/